ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 22 өдөр Дугаар А/35 Улаанбаатар хот

Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх,
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2008 оны Журам батлах тухай 185 дугаар тушаал, НЭМГ-ын даргын 2017 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн А/64 тоот тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэдэсний халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажилласугай.

2. Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нар дараах үйл ажиллагааг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулсугай.

2.1 Гэдэсний халдварт өвчин, А вируст непатит өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Гар угаах" 6 сарын аяныг зохион байгуулж, ЕБС, цэцэрлэг аж ахуй нэгж иргэдийн дунд гараа зөв угаах дадлыг төлөвшүүлэх сургалт сурталчилгааг эрчимжүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах

2.2 Ус түгээх, хүнсний зах, худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны газрын ажилчдад хүнсний болон усны аюулгүй байдлыг хангуулах талаар дүүргийн холбогдох хэлтэс албадтай хамтран гэдэсний халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах

2.3 Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих хордлогот халдварын сэжигтэй тохиолол болон хавьтлыг эрт илрүүлэх, өвчтөнийг тусгаарлах сорьц шинжлэгдэхүүн авах, бүртгэх, мэдээллэх, голомтонд зохих хариу арга хэмжээг авах

2.4 Үйл ажиллагааны явцын тайланг сар бүрийн 23-ны дотор, аяны хугацаанд хэрэгжүүлсэн ажлын нэгдсэн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны дотор Тархвар судлаач эмч Д.Ичинхорлоод ирүүлэх.

3. Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, хэрэгжүүлсэн ажлын тайланд дүгнэлт хийн удирдлагын зөвлөлд танилцуулахыг тархвар судлаач эмч /Д.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай

4. Гэдэсний халдварт өвчин, хоол хүнсээр дамжих халдварт өвчнөөс сэргийлэх талаар ард иргэдэд өргөнөөр сурталчилахыг Сургалт хариуцсан мэргэжилтэн /Б.Билэгбат/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Э.БОДЬЦЭЦЭГ

ТТЕ2350 №.9120262